



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 04 дугаар сарын 10

Дугаар А/1238

Улаанбаатар хот

Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц,
орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.1 дэх заалт, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 2.1, 2.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргийн хүн ам, ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо болон үйлчилгээний хамрах хүрээг харгалзан “Баянзүрх, Баянгол, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг нэгдүгээр, “Багануур, Багахангай, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг хоёрдугаар, “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын орон тооны хязгаар”-ыг гуравдугаар, “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын орон тоо, албан тушаалын жагсаалт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан бүтцийн нэгжийн дарга, байцаагч, ажилтнуудыг томилон ажиллуулах, албан тушаал нь хасагдсан албан хаагчийг сул орон тоонд шилжүүлэн ажиллуулах, нэгжүүдийн чиг үүрэг, шаардлагатай ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлахыг дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, шаардлагатай албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Даваахүү)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Даваахүү)-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/52 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА


Б.БАТЖАРГАЛ



1525010823

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн
А/1238 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАЯНЗҮРХ, БАЯНГОЛ, ЧИНГЭЛТЭЙ, ХАН-УУЛ, СҮХБААТАР,
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



№	Нийгмийн даатгалын газрын нэр	Зохион байгуулалтын бүтэц					
		Дарга	Захиргаа хяналтын хэлтэс	Санхүү бүртгэлийн хэлтэс	Хамралт, орлогын хэлтэс	Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс	Улиастай дахь Нийгмийн даатгалын хэлтэс
1	Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа хяналтын хэлтэс	Санхүү бүртгэлийн хэлтэс	Хамралт, орлогын хэлтэс	Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс	Улиастай дахь Нийгмийн даатгалын хэлтэс
2	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа хяналтын хэлтэс	Санхүү бүртгэлийн хэлтэс	Хамралт, орлогын хэлтэс	Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс	-
3	Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа хяналтын хэлтэс	Санхүү бүртгэлийн хэлтэс	Хамралт, орлогын хэлтэс	Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс	Хайлааст дахь Нийгмийн даатгалын хэлтэс
4	Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа хяналтын хэлтэс	Санхүү бүртгэлийн хэлтэс	Хамралт, орлогын хэлтэс	Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс	Яармаг дахь Нийгмийн даатгалын хэлтэс
5	Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа хяналтын хэлтэс	Санхүү бүртгэлийн хэлтэс	Хамралт, орлогын хэлтэс	Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс	-
6	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар	Дарга	Захиргаа хяналтын хэлтэс	Санхүү бүртгэлийн хэлтэс	Хамралт, орлогын хэлтэс	Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэс	Баянхошуу дахь Нийгмийн даатгалын хэлтэс

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн
Мэддугаар тушаалын гуравдугаар хавсралт



ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Нийгмийн даатгалын байгууллагын нэр	Нийт орон тоо	Үүнээс		Үүнээс	
			ТЗ	ТҮ/ТҮМ	Удирдах	Гүйцэтгэх
1	Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газар	75	62	13	6	69
2	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газар	58	48	10	5	53
3	Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар	52	41	11	6	46
4	Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газар	59	48	11	6	53
5	Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар	53	40	13	5	48
6	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар	60	46	14	6	54
7	Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар	18	12	6	4	14
8	Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар	5	4	1	1	4
9	Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар	19	12	7	4	15
	Нийт	399	313	86	43	356

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн
Мэз дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ОРОН ТОО, АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал	Орон тоо
Нэг.Удирдлага			1
1	Газрын дарга	T3	1
Хоёр.Захиргаа, хяналтын хэлтэс			19
2	Хэлтсийн дарга	T3	1
3	Хяналт шалгалтын улсын байцаагч	T3	6
4	Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч	T3	1
5	Хүний нөөцийн мэргэжилтэн	T3	1
6	Хуулийн мэргэжилтэн	T3	1
7	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	T3	1
8	Мэдээллийн технологи, цахим үйлчилгээ хариуцсан ажилтан	TY	1
9	Бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан ажилтан	TYM	1
10	Архивын ажилтан	TYM	2
11	Үйлчлэгч	TY	2
12	Төсвийн байгууллагын үйлчилгээний ажилтан	TY	2
Гурав.Санхүү бүртгэлийн хэлтэс			7
13	Хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч	T3	1
14	Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн	T3	2
15	Сангийн нягтлан бодогч	TYM	2
16	Үйл ажиллагааны нягтлан бодогч	TYM	1
17	Хөрөнгө хариуцсан ажилтан	TY	1
Дөрөв.Хамралт, орлогын хэлтэс			8
18	Хэлтсийн дарга	T3	1
19	Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч, мэргэжилтэн	T3	6
20	Сайн дурын даатгалын байцаагч, мэргэжилтэн	T3	1
Тав.Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс			18
21	Хэлтсийн дарга	T3	1
22	Тэтгэврийн хяналтын байцаагч, мэргэжилтэн	T3	2
23	Тэтгэмжийн хяналтын байцаагч, мэргэжилтэн	T3	2
24	Тэтгэврийн тогтоолт, олголтын байцаагч, мэргэжилтэн	T3	3
25	Тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч, мэргэжилтэн	T3	2
26	Магадлагч эмч	TY	1
27	Нэг цэгийн үйлчилгээний ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн	T3	1
28	Нэг цэгийн үйлчилгээний байцаагч, мэргэжилтэн	T3	6
Нийт орон тоо			53